Асгаралт үүссэн шалтгаан:	Тайлбар			
Шингэнийг хэт дүүргэсэн				
Техникийг зүй бус ашигласан				
Буруу техник ашигласан				
Сургалт хангалтгүй				
Жийргэвч сэтэрсэн				
АА-н системийн алдаа				
Дамжуулах хоолой задарсан	✓			
Бусад				
Мэдээлэх хуудас бэлтгэсэн ажилтны овог нэр:	ББямбаргал			
Албан тушаал: Засвар Мастэр	Гарын үсэг:	<input checked="" type="checkbox"/>	Огноо:	15/17.



Зураг.49 Асгаралтын урьдчилсан мэдээлэл, тайлан



Зураг.50 Нефтийн бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд авах арга хэмжээ

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК нь “Хаан булаг интернэйшнл” ХХК-ний Төв аймгийн Заамар сумын нутагт MV-005028 тус тусгай зөвшөөрлийн талбайд алтны шороон ордын ашиглалт олборлолт явуулж байгаа бөгөөд жил бүр орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орчны хяналт шинжилгээний ажлыг 2023 оны 5 сард “И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК-ийн экологич Э.Мөнгөнтуяа, байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн Түвшинбат, Ө.Ундрах, ургамал судлаач Д.Отгонцэцэг нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн.

Хавсралт.22 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан 5 ба 8 сар

10.1 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Тус ажлын хүрээнд бид уурхайн карьер, тээвэрлэлтийн зам, хотхоны орчим зэрэг газар агаарт буй ширхэглэгт тоосонцорыг “Dust truck” багажаар, “Environmental meter” багажаар дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил, салхины хурд, агаарын температур, гэрлийн хүч зэргийг хэмжиж суурин боловсруулалтын хүрээнд тус хэмжиж авсан хэмжилтийг “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарттай харьцуулсан



Зураг.51 Агаарын хяналт шинжилгээний багаж



Зураг.52 Агаарын чанарын хэмжмилт

Агаарын тоосжилтын үр дүн:

Монгол Улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарт нийт тоосны агууламж TSP мг/м³, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл зэрэг үзүүлэлт нь 24 цагийн дундажаар бидний хэмжилт хийсэн газруудад агаарын техникийн ерөнхий шаардлага стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 6. Агаарт буй тоосонцорыг хэмжсэн үзүүлэлтүүд 5 сар 8 сар

№	Байршил	Сар өдөр	Хүхэрлэг хий /SO ₂ / мг/м ³	Азотын хий /NO ₂ / мг/м ³	Нийт Тоосны агууламж TSP мг/м ³	Дуу чимээ дБА	Чийг-шил
1.	Каррьер	05/08	0.020	0.056	0.231	30	max 40.4% min 18.4%
2	Хотхон	05/08	0.019	0.048	0.350	40	max 40.4% min 18.4%
	MNS 4585:2016 стандарт	-	0.450	0.200	0.500	60.0 дБА	40-60%

10.2 ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Хяналт шинжилгээний ажлын хүрээнд уурхайн засварын талбай, шатахуун түгээх газар, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хөрс, шимт хөрс зэргээс хөрсний дээж авлаа.



Зураг.53 Засварын талбайгаас дээж авч буй байдал



Зураг.54 Хог хаягдлын цэгээс хөрсний дээж авч буй байдал

10.2.1 Уурхайн шимт хөрсний шинжилгээ

Уурхайн шимт хөрсийг хуулахдаа 0.2м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолсон. Тус шимт хөрснөөс дээж авч хөрсний шимт чанарыг тодорхойлуулсан.



Зураг.55. Шимт хөрсний дээж авч буй байдал

10.3 УУРХАЙН УСНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

10.3.1 Уурхайн унд ахуйн усны шинжилгээ, хяналт

Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд нийт 30-50 хүн ажиллаж амьдарна. Унд ахуйн усны хэрэгцээг өрөмдсөн гүний худгийн усаар хангана. Гүний худгийн усанд шүүлтүүр тавьсан бөгөөд бид 5 дугаар сарын хяналт шинжилгээний ажлын хүрээнд тус уурхайн унд ахуйн усанд бактериологийн болон унд ахуйн усны ерөнхий шинжилгээг тус тус хийлгэж стандарт үзүүлэлттэй харьцуулсан болно.



Зураг.56 Ундны усны дээж авч буй байдал

10.3.2 Уурхайн технологийн усны шинжилгээ

Уурхайгаас баруун хойд байрлах цэвэр, бохир нуурыг элс баяжуулахад ашигладаг. Уурхайн элс баяжуулах хэсгийн хаягдлын сан, цэвэр нуурын уснаас тус тус дээж авч, цэврийн нуурын усны гадаргын усны шинжилгээг Монгол-Ус ТӨҮГазарт хийлгэсэн болно.



Зураг.57. Уурхайн цэвэр болон бохир нуурын харагдах байдал



Зураг.58 Уурхайн цэвэрийн нуурын уснаас дээж авч буй байдал



Зураг.59 Уурхайн цэвэр, бохирын уснаас дээж авч буй байдал

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


11.1 Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг мэргэжлийн ажилтан, багт хариуцуулах

Орон тооны байгаль очны мэргэжилтэн ажилуулдаг ба байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих ажлыг дотоод журмаар зохицуулсан. Байгаль орчны мэргэжилтэн тухайн гүйцэтгэсэн ажил үүргээ уурхайн удирдлагад долоо хоног, сараар, хагас жил, жилийн эцсээр бүрэн тайлагнаж хянуулдаг. Мөн нөхөн сэргээлтийн туслах орон тооны дөрвөн ажилтныг ажлын байраар ханган ажиллаж байна.



Зураг.60 Уурхай нөхөн сэргээлтэд гар бие оролцсон ажилчид

11.2 Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэж өгөх



Зураг.61 Тухайн жилийн ажлын төлөвлөгөө

11.3 Уурхайн ажиллагсдын дунд байгаль хамгаалах талаар ухуулга яриа, сурталчилгааны ажил зохион байгуулах,

Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Газар чандмань” ххк-аар 2023.06-р сарын сургалтаар Монгол орны ургамлын аймгийн тухай ерөнхий мэдлэг олгох, уурхайн ойролцоо түгээмэл тархсан хөл газрын ургамлуудыг таних, тэдгээртэй тэмцэх арга замуудыг зөвлөх зорилгоор бэлтгэв. Мөн 8 сард “Дэлхийн усны нөөцийн өнөөгийн нөхцөл байдал болоод ус дахин ашиглах хэрэгцээ шаардлага” гэсэн сэдвүүдээр сургалт авлаа.



Зураг.62 Сургалтад хамрагдсан ажилчид

11.4 Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах

2023 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар Заамар сумын БОУБ болон байгаль хамгаалагч, Засаг дарга-д тухай бүрт нь БОМТ-ийн хэрэгжилтийн танилцуулж, ажилласан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2023 оны 3 сарын 6 ны өдөр төрийн захиргааны төв байгууллагаар 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан ажилласан.

11.5 Шатахуун хадгалах, түгээх станцын галын аюулгүй ажиллагааг найдвартай хангаж, тос шатахуун алдах, хаях, уурших явдлыг гаргахгүй байхад онцгой анхаарах



Зураг. 63 ШТС-д ажлын байорны үзлэг хийв.

2023 онд Төв аймгийн онцгой байдлын газраас шатахуун хадгалах, түгээх станц, ажлын байр тус бүр дээр галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулан ажилласан.

Шатахуун хадгалах, түгээх станцын галын аюулгүй ажиллагааг найдвартай хангаж, тос шатахуун алдах, хаях, уурших явдлыг гаргахгүй байхад онцгой анхаарж ажилчидад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгж ажилласан. *Хавсралт 23 / Галын аюулгүй байдлын дүгнэлт /*

12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

12.1 Заамар сумын Хайлааст багийн иргэд

Уурхайн нөлөөллийн бүсэд орших малчдад нөхөн сэргээлт болон уулын ажлын явцыг танилцуулсан мөн 2023 оны 4 сард хуралдсан багийн нийтийн хуралд нөхөн сэргээлтийн тайланг танилцуулав.



Зураг.64 Нөлөөллийн бүсэд орших малчдад нөхөн сэргээлтийн ажлыг танилцуулав.

12.2 Төв аймгийн Байгаль орчны газар

Уг онд хийгдсэн ажлын тайланг болон нийт хийгдсэн ажлыг 2023 оны 4 сард Багийн нийтийн хурал дээр Хайлааст багийн малчдад танилцуулсан. Мөн нөхөн сэргээлт хүлээж авах улсын комисст 10 сарын 11 ны өдөр талбай дээрээ хүлээлгэн өгсөн.

12.3 Төрийн захиргааны төв байгууллага

Цахим систем болох www.eic.mn 11 сарын 1-ний дотор бичвэр мэдээллийг орууллаа.

12.4 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

Хүснэгт 7. Байгаль орчныг хамгаалах зардлын нэгдэл

Д/д	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Үнийн дүн / мян.төг /	Үнийн дүн / мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2 700.0	2 700.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	25 250.0	83,208.68
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5 300.0	32,533.58
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 400.0	1 400.0
7	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	800.0	1 000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	1 500.0	1 500.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 000.0	1 000.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-	-
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт		37 950.0	90 808.68

13 ДҮГНЭЛТ

2023 онд биологийн нөхөн сэргээлтийг хадлан бэлчээрийн чиглэлээр хийсэн болно. Тарилтанд олон наст тухайн орон нутагт элбэг тархацтай ботуул, согоовор ерхөг гэсэн өвслөг ургамал мөн нэг наст тэжээлийн ургамал овъоёс, судан өвсийг 1:1:1:1 гэсэн харьцаатай үрийн холимог ашиглав. Тэжээлийн ургамал нь хөрсийг үндэсний системээр баяжуулан хөрсний шимэрхэг чанарыг дээшлүүлж, салхин нөмрөг үүсгэж өгдөг үр ашигтай. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хашиж хамгааллаж усалгаа арчилгаа хийснээр ургамлын ургалтын бүхий л үе шат хэвийн сайн явагдсан бөгөөд 9 сарын сүүлийн 10 хоногт үр боловсролт гүйцэж үрээ хаясан болно. Төлөвлөгөөт онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн ба бид тайланд төлөвлөгөөт аудит хийлгэсэн мөн “ Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд 4200 ширхэг мод тарилаа. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллаа. Бид цаашдын үйл ажиллагаандаа Монгол улсад мөрдөгдөж байгаа байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын стандарт нормуудыг баримтлан ажиллана.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000232140

2017.06.15

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011652113

/ Хувийн хэргийн дугаар /

6195598

/ Регистрийн дугаар /

Хаан булаг интернэйшнл

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2017.06.14

/ он, сар, өдөр /

4610

Гадаад худалдаа

8299

Бизнесийн зөвлөгөө өгөх

7320

Төсөл боловсруулах

7911

Аялал жуулчлал

08100

Ашигт малтмал ашиглах /2007.01.29-2037.01.29/

/ Код /

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

3,010,000.00

/ хорөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 11-р хороо, зайсан, зайсангийн тойруу, 21/1 байр ММ проперти барилга
1-3 давхар, Утас1: 77249999, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

/ тэмдэг /

Т.ЗУЛЗАЯА

/ гарын үсэг /

Гэрчилгээ дахин олгосон 2021 он 07 сар 09 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Самбуу овогтой Идэр-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.06.15	Б.Батзориг
2	Дахин гэрчилгээ олгов.	2021.07.09	Т.Зулзаяа
3	Бямба овогтой Баярбаатар-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.09.21	Л.Пүрэвжаргал



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 5028А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Төв аймаг /хот/-ийн
Завсар сум /дүүрэг/-ын
Ар наймганы дунд хэсэг нэртэй газарт орших
1252 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд
заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зөвшөөрч улсын бүртгэлийн 9019007011 тоот гэрчилгээтэй
„Атлан горнод монгол“ ХХК -д
энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.



АМТХЭГ-ЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ

ДАРГА

Ц. ГАНХУЯГ

2007 оны 01 сарын 29 өдөр













Улаанбаатар хот

5028A

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ 2901 ТООТ ЛИЦЕНЗИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ






ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН (гэрчилгээгүй бол хүчингүй)

Лицензээр олгогдсон талбайн хэмжээ болон лицензийн эзэмшилд орсон оорчлолт

№	Лицензэд орох оорчлолтийн үндэслэл	Өргөдлийн бүртгэлийн дугаар	Хасагдах талбайн хэмжээ (га-аар)	Үлдсэн талбайн хэмжээ (га-аар)
1.	Анх олгогдон	6658A	-	
2.	Лицензийг №354 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Газпромбанк" -д барьцаалуулсныг ГУУКА-ны даргын 2003 оны 43 тоот ишийдвэрээр бүртгэв.	165A		
3.	Лицензийн хоёр дахь жилийн төлбөрөө төлөв.			
4.	Лицензийн гурав дахь жилийн төлбөрөө төлөв.			
5.	Лицензийн 4 дахь жилийн төлбөрөө төлөв.			
6.	Лицензийг "Газпромбанк" ны 2005-12-22-ны өдрийн 08/5685 тоот хүсэлтийг үндэслэн барьцаалуулсныг бүртгэв.	498.1		
7.	Лицензийг 1027700167110 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Газпромбанк" ны даргын 2006 оны 219 тоот ишийдвэрээр бүртгэв.	498.1		
8.	Лицензийн 5 дахь жилийн төлбөрөө төлөв			
9.	Тусгай зөвшөөрлийн зургийн дахь жилийн төлбөрөө төлөв.			
10.	Тусгай зөвшөөрлийн 7 дахь жилийн төлбөрөө төлөв.			
11.	Тусгай зөвшөөрлийн 8 дахь жилийн төлбөрөө төлөв.			

5028 А
АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ТООТ ЛИЦЕНЗИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН (гэрчилгээгүй бол хүчингүй)

Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын оорчлолтууд

№	Солбицлууд оорчлогдох үндэслэл	Хүчин тоголдор солбицлууд
1.	Талбайн анхны солбицлууд	1. 104°29'00" 48°17'43" 28. 104°29'59.92" 48°17'34.36" 2. 104°29'05.74" 48°17'43" 29. 104°29'59.91" 48°17'36.17" 3. 104°29'05.74" 48°17'42.4" 30. 104°29'53.21" 48°17'36.13" 4. 104°29'11.34" 48°17'42.43" 31. 104°29'53.19" 48°17'37.36" 5. 104°29'11.34" 48°17'41.91" 32. 104°29'40.49" 48°17'37.31" 6. 104°29'15.71" 48°17'41.93" 33. 104°29'40.47" 48°17'39.37" 7. 104°29'15.72" 48°17'40.96" 34. 104°29'32.71" 48°17'39.93" 8. 104°29'21.05" 48°17'40.98" 35. 104°29'32.68" 48°17'42.52" 9. 104°29'21.07" 48°17'39.3" 36. 104°29'24.92" 48°17'42.49" 10. 104°29'24.95" 48°17'39.32" 37. 104°29'24.95" 48°17'43" 11. 104°29'24.98" 48°17'36.92" 38. 104°30'35" 48°17'43" 12. 104°29'30.8" 48°17'36.95" 39. 104°30'35" 48°16'50" 13. 104°29'30.82" 48°17'34.94" 40. 104°32'00" 48°15'50" 14. 104°29'34.7" 48°17'34.96" 41. 104°33'30" 48°15'50" 15. 104°29'34.72" 48°17'33.01" 42. 104°33'30" 48°14'47" 16. 104°29'50.24" 48°17'33.08" 43. 104°32'53" 48°14'47" 17. 104°29'50.26" 48°17'32.08" 44. 104°32'53" 48°14'30" 18. 104°30'06.07" 48°17'32.08" 45. 104°31'15" 48°14'30" 19. 104°30'06.08" 48°17'32.15" 46. 104°31'15" 48°15'00" 20. 104°30'09.67" 48°17'32.15" 47. 104°30'36" 48°15'00" 21. 104°30'09.68" 48°17'31.92" 48. 104°30'36" 48°16'10" 22. 104°30'11.67" 48°17'31.92" 49. 104°30'00" 48°16'10" 23. 104°30'11.66" 48°17'30.75" 50. 104°30'00" 48°17'00" 24. 104°30'13.54" 48°17'30.72" 51. 104°29'36" 48°17'00" 25. 104°30'13.52" 48°17'32.86" 52. 104°29'36" 48°17'16" 26. 104°30'06.05" 48°17'32.83" 53. 104°29'00" 48°17'16" 27. 104°30'06.04" 48°17'34.38"
2.	Лицензийг №354 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Газпром банк"-д барьцаалуулсныг ГУУКА-ны даргын 2003 оны 43 тоот шийдвэрээр бүртгэв.	2002-10-23  Д. Гэрэлгуйа Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 
3.	Лицензийн хоёр дахь жилийн төлбөрөө тоолов.	Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр. 
4.	Лицензийн гурав дахь жилийн төлбөрөө тоолов.	Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр №2004-10-19 
5.	Лицензийн 4 дахь жилийн төлбөрөө тоолов.	Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2005-10-14 



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, гарын үсэг, огноо, тамга
000-C1	<ul style="list-style-type: none">Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.	1252.6 Га	0 Га	1 104° 30' 36" 48° 17' 44.83" 2 104° 30' 36" 48° 16' 51.82" 3 104° 32' 1.01" 48° 15' 51.82" 4 104° 33' 31" 48° 15' 51.82" 5 104° 33' 31" 48° 14' 48.81" 6 104° 32' 54" 48° 14' 48.81" 7 104° 32' 54" 48° 14' 31.81" 8 104° 31' 16" 48° 14' 31.81" 9 104° 31' 16" 48° 15' 1.82" 10 104° 30' 37" 48° 15' 1.82" 11 104° 30' 37" 48° 16' 11.82" 12 104° 30' 1.01" 48° 16' 11.82" 13 104° 30' 1.01" 48° 17' 1.82" 14 104° 29' 36.94" 48° 17' 1.8" 15 104° 29' 36.94" 48° 17' 17.8" 16 104° 29' 0.94" 48° 17' 17.8" 17 104° 29' 0.94" 48° 17' 44.82" 18 104° 29' 6.68" 48° 17' 44.82" 19 104° 29' 6.68" 48° 17' 44.21" 20 104° 29' 12.27" 48° 17' 44.24" 21 104° 29' 12.27" 48° 17' 43.72" 22 104° 29' 16.65" 48° 17' 43.74" 23 104° 29' 16.65" 48° 17' 42.77" 24 104° 29' 21.98" 48° 17' 42.78" 25 104° 29' 22.01" 48° 17' 41.11" 26 104° 29' 25.88" 48° 17' 41.14" 27 104° 29' 25.92" 48° 17' 38.73" 28 104° 29' 31.73" 48° 17' 38.76" 29 104° 29' 31.76" 48° 17' 36.75" 30 104° 29' 35.63" 48° 17' 36.77" 31 104° 29' 35.66" 48° 17' 34.82" 32 104° 29' 51.18" 48° 17' 34.89" 33 104° 29' 51.2" 48° 17' 33.88" 34 104° 30' 7.08" 48° 17' 33.9" 35 104° 30' 7.08" 48° 17' 33.97" 36 104° 30' 10.68" 48° 17' 33.97" 37 104° 30' 10.69" 48° 17' 33.75" 38 104° 30' 12.68" 48° 17' 33.75" 39 104° 30' 12.67" 48° 17' 32.58" 40 104° 30' 14.55" 48° 17' 32.54" 41 104° 30' 14.52" 48° 17' 34.68" 42 104° 30' 7.05" 48° 17' 34.65" 43 104° 30' 7.05" 48° 17' 36.2" 44 104° 30' 0.86" 48° 17' 36.16" 45 104° 30' 0.84" 48° 17' 37.98" 46 104° 29' 54.14" 48° 17' 37.94" 47 104° 29' 54.13" 48° 17' 39.17" 48 104° 29' 41.43" 48° 17' 39.12" 49 104° 29' 41.41" 48° 17' 41.18" 50 104° 29' 33.65" 48° 17' 41.74" 51 104° 29' 33.61" 48° 17' 44.33" 52 104° 29' 25.85" 48° 17' 44.29" 53 104° 29' 25.88" 48° 17' 44.82"








2010-04-01
КАДАСТРЫН КЭЛТЭЭ
УХАА 2/12
Э.Заяабат



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.








Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
000-CI	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.	 2010-04-01
002-PL	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-д барьцаалахКадастрын хэлтсийн даргын 2003.01.23-ний 43 тоот шийдвэр	 2003-01-23
003-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2003.10.23 – 2004.10.23 хүртэл	 2003-05-12
004-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2004.10.23 – 2005.10.23 хүртэл	 2004-10-19
005-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2005.10.23 – 2006.10.23 хүртэл	 2005.10.14
006-PE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-ийн барьцаанаас чөлөөлөхКадастрын хэлтсийн даргын 2005.12.22-ний 08/5685 тоот шийдвэр	 2005-12-22
007-PL	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-д барьцаалахКадастрын хэлтсийн даргын 2006.02.10-ний 219 тоот шийдвэр	 2006-02-10



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.








Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2006.10.23 – 2007.10.23 хүртэл	 200608-15
009-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2007.10.23 – 2008.10.23 хүртэл	 2007-08-10
010-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2008.10.23 – 2009.10.23 хүртэл	 2008.08.25
011-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2009.10.23 – 2010.10.23 хүртэл	 2009-10-20
012-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2010.10.23 – 2011.10.23 хүртэл	 2010-09-21
013-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2011.10.23 – 2012.10.23 хүртэл	 2011-10-03
014-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.10.23 – 2013.10.23 хүртэл	 2010-10-08



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
015-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.10.23 – 2014.10.23 хүртэл	 <p>2013-10-10</p>
016-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.10.23 – 2015.10.23 хүртэл	 <p>2014-09-16</p>
017-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.10.23 – 2016.10.23 хүртэл	 <p>2015-09-08</p>
018-TF	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9011165058 тоот улсын бүртгэлийн дугаартай Монгол майнинг энд эксплорэйшн ХХК-д шилжүүлэхКадастрын хэлтсийн даргын 2016.10.13-ний 67 тоот шийдвэр	 <p>201610-13</p>
019-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 15 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.10.23 – 2017.10.23 хүртэл	 <p>2016-10-18</p>
020-PE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-ийн барьцаанаас чөлөөлөхКадастрын хэлтсийн даргын 2017.02.21-ний 91 тоот шийдвэр	 <p>2017-02-21</p>
021-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 16 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.10.23 – 2018.10.23 хүртэл	 <p>2017-10-18</p>



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
022-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 17 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.10.23 – 2019.10.23 хүртэл	<p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС 2018-10-03</p>
023-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 18 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.10.23 – 2020.10.23 хүртэл	<p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС 2019-11-04</p>
024-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 19 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.10.23 – 2021.10.23 хүртэл	<p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС 2020-10-16</p>
025-TF	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9011652113 тоот улсын бүртгэлийн дугаартай Хаан булаг финанс ХХК-д шилжүүлэхКадастрын хэлтсийн даргын 2020.10.26-ний 411 тоот шийдвэр	<p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595 2020-10-26</p>
026-CN	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэрийг 9011652113 тоот улсын бүртгэлийн дугаартай Хаан булаг интернэйшнл ХХК болгон өөрчлөх. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн компаний оноосон нэрийг өөрчлөв.Кадастрын хэлтсийн даргын 2021.08.25-ний --- тоот шийдвэр	<p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595 2021.08.25</p>




ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Кадастрын лавлагаа

Лавлагааны мэдээлэл

Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашигт малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-005028
Талбайн нэр	Ар наймганы дунд хэсэг
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	1252.60
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Хаан булаг интернэйшнл
Аймаг, сум, сав газрын нэр	Төв аймаг Заамар сум, Туул голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхцсан талаарх мэдээлэл	



ТАНИХ ТЭМДЭГ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

- Ашиглалтын
- Хайгуулын

Засаг захиргааны хил

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв

Тусгай хамгаалалттай газар нутаг

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн ноёд газар
- Дурсгалт газар

Хамгаалалтын бүсүүд

- Гол мөрний урсац бүрэлдэх эх
- Ойн сан бүхий газар

Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

- Онцгой хамгаалалтын бүс
- Энгийн хамгаалалтын бүс


Ус хангамжийн эх үүсвэр

- Эрүүл ахуйн хориглолтын бүс
- Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
- Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

- Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:53138.0





ТУУЛ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 62 дугаартай албан бичиг, "Усны газар"-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/334 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 52 "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


НЭГ. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-0050208 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Ар наймганы дунд хэсэг, жалга 3,4"-т байрлах алтны шороон ордоос 110'300.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэгцээнд шаардагдах 21'780.0 м³ усыг уурхайн ухлагын шүүрлийн шавхан зайлуулах уснаас, 136'168.0 м³ усыг Туул голоос, унд ахуйн хэрэглээний 5'400.0 м³ усыг өөрийн эзэмшлийн гүний 1 худгаас 2023 онд ашиглахыг "Хаан булаг интернэйшнл" ХХК-д зөвшөөрсүгэй.

ХОЁР. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга /П.Энхбаяр/, Туул голын сав газрын захиргааны менежерийн албан үүрэг гүйцэтгэгч /Д.Жаргал/ нарт үүрэг болгосугай.

ГУРАВ. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, ус ашиглалтын тайланг 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг "Хаан булаг интернэйшнл" ХХК /С.Идэр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НЯМДОРЖ



БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НЯМДОРЖ

2023 оны 04 дүгээр сарын 10

БАТЛАВ
“ХААН БУЛАГ ИНТЕРНЭЙШНЛ” ХХК
-ИЙН ЗАХИРАЛ

С.ИДЭР

2023 оны 04 дүгээр сарын ...

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 23/10

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Усны газар”-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/334 дугаар албан бичгийн хавсралт Дугаар 52 тоот ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/19 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрөл, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 62 дугаартай албан бичгийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан тойруу гудамж, Зайсан ам, ММ property, 501 тоотод байрлах Улсын бүртгэлийн 9011652113 дугаартай, 6195598 регистрийн дугаартай “Хаан булаг интернэйшнл” ХХК-ийн Төлөвлөлтийн инженер Б.Баярбаатар нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 /Нэг/ жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-0050208 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Ар наймганы дунд хэсэг” алтны шороон ордын үйлдвэрлэл технологийн болон бусад хэрэгцээнд шүүрлийн ус болон Туул голоос ус ашиглана.

2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.4-т заасны дагуу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 110'300.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд ашиглах ус 185'128.0 м³/жил;

2.2.1. Унд, ахуйд: 5'400.0 м³/жил;

2.2.2. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах гадаргын ус: 148'800.0 м³/жил;

2.2.3. Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын ус: 6'400.0 м³/жил;

2.2.4. Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах гадаргын ус: 748.0 м³/жил;

2.2.5. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ашиглах гадаргын ус: 2'000.0 м³/жил;

2.2.6. Уурхайн ухлагаас шавхан зайлуулж ашиглах газрын доорх ус: 21'780.0 м³/жил;

2.3. *Усны чанар, найрлага:* 2023 оны 06, 09, 11 дүгээр сард хаягдлын нуурын уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. Байршил: Унд ахуйн усыг өөрийн эзэмшлийн 1 худгаас, технологийн болон бусад хэрэглээний усыг уурхайн шүүрлийн усаар болон Туул голоос хангана. Худгийн байршлын солбицол: 48°17'25.94", 104°29'12.04".

2.4.2. Барилга байгууламж: Эргэлтийн усан сангаас баяжуулах төхөөрөмжид ус дамжуулах 150.0 мм голчтой, 250.0 м урт шугам сүлжээтэй, тунаах сангийн эзлэхүүн 80'000.0 м³. Туул голоос усан санд 200 мм голчтой 8.6 км урт хоолойгоор ус татна. Тусгаарлах далангийн дунд 50.0 м урттай, 800 мм голчтой хос хоолойгоор ус халиагуур хийж эргэлтийн усан сан, тунаах сан хоёрыг хооронд нь холбоно.

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Уурхайн олборлолтод LIUGONG маркийн утгуурт ачигч 3 ш, KOMATSU маркийн бульдозер 1 ш, HOWO маркийн автосамосвал 15 ш, CATERPILLAR маркийн экскаватор 3 ш, DOOSAN маркийн экскаватор 1 ш тус тус ашиглана. Баяжуулах үйлдвэрт 50 тн/цаг хүчин чадалтай хүрдэт шигшүүр 1 ш, Sagar маркийн хүрдэт шигшүүр 1 ш, насос 1 ш, тунаах машин 1 ш, хоригт цорго 2 ш, сеператор 1 ш тус тус ашиглана.

2.4.4. Насосны хүчин чадал: Туул голоос MD-100-80x7 маркийн 100 м³/цаг хүчин чадалтай насосоор эргэлтийн санд ус татдаг.

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:* Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг мөрдлөг болгоно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:*

2.6.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу төлбөр тооцно.

2.6.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам"-ын дагуу тохижуулж ашиглана.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:*

2.7.1. Туул голоос ус татах насосыг байрлуулахдаа голын эрэг, голдирлыг хөндөхгүйгээр байрлуулна.

2.7.2. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах.

2.7.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

2.7.4. Биологийн нөхөн сэргээлт 1.87 га талбайд хийнэ. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 5000 ш мод тарина.

2.8. *Усны тоолуур:* Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллана. Унд ахуйн худагт тоолуур суурилуулж, тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.9.1. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах 136'168.0 м³ гадаргын усны нөөц ашигласны төлбөрт 81'221'488.0 /Наян нэгэн сая хоёр зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун наян найман/ төгрөг, 21'780.0 м³ газрын доорх усны нөөц ашигласны төлбөрт 21'588'336.0 /Хорин нэгэн сая таван зуун наян найман мянга гурван зуун гучин зургаан/ төгрөг, нийт **102'809'824.0** /Нэг зуун хоёр сая найман зуун есөн мянга найман зуун хорин

дөрвөн/ төгрөгийг Төв аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 40 хувийг хоёрдугаар, 60 хувийг гуравдугаар улиралд төлнө.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүдгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцоор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж буй усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Туул голын сав газрын захиргааны менежер

...../Д.ЖАРГАЛ/

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга

...../П.ЭНХБАЯР/

Усны үнэ тариф, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

...../Н.БОЛОР-ЭРДЭНЭ/

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,
2-р хороо, Чингүнжавын гудамж,
Туул голын сав газрын захиргааны байр, 203 тоот өрөө.

Харилцах утас: (976) 70003716,
(976) 70003714.

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ХААН БУЛАГ ИНТЕРНЕЙШНЛ” ХХК-ийн Төлөвлөлтийн инженер

...../Б.БАЯРБААТАР/

Байгаль орчны мэргэжилтэн

...../Э.НАМСРАЙ/

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
11-р хороо, Зайсан тойруу гудамж,
Зайсан ам, ММ property, 501 тоот.

Харилцах утас: (976) 77445777,
(976) 89050515.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2023-03-31 № 01/334

танай 2023-03-06 -ны № 44 -т

□ “ХААН БУЛАГ ИНТЕРНЭЙШНЛ” ХХК-д

Танай байгууллагын 2023 оны 44 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Усны тухай хуулийн 28.4 дэх заалтын дагуу Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах “Ар наймганы дунд хэсэг, жалга-3,4” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Туул голын сав газрын захиргаанд

Хавсралт: ...хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.БОЛДБААТАР



162330817

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 03 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар: 52

Улаанбаатар хот
Утас: 51-265530

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Хаан булаг интернэйшнл" ХХК, захирал С.Идэр, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан тойруу гудамж, Зайсан ам, ММ Property, 5 давхарт, 501 тоот, утас: 77445777, 89050515, И-мэйл: admin@khaanbulag.mn, улсын бүртгэлийн дугаар: 9011652113, регистрийн дугаар: 6195598.

2. Төслийн нэр, байршил:

"Хаан булаг интернэйшнл" ХХК-ийн эзэмшлийн Төв аймгийн Заамар сумын нутагт "Ар наймганы дунд хэсэг, жалга-3,4" нэртэй газарт орших MV-005028 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 230 км, Дархан хотоос баруун урд зүгт 220 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун тийш 32 км-т байрладаг. Туул голын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч: "Хаан булаг интернэйшнл" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат: /X, Y/

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-005028, талбайн хэмжээ: 1,252.6 га, (Солбицлын 53 цэгтэй)

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104°30'36"	48°17'44.83"	6	104°29'12.27"	48°17'44.24"
2	104°30'36"	48°16'51.82"	7	104°29'22.01"	48°17'41".11
3	104°33'31"	48°14'48.81"	8	104°29'35.63"	48°17'36.77"
4	104°30'37"	48°15'1.82"	9	104°30'7.08"	48°17'33.97"
5	104°29'36.94"	48°17'17.8"	10	104°29'25.88"	48°17'44.82"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:

Алтны шороон ордыг ил аргаар олборлон, гравитацийн аргаар угаан баяжуулах.

6. Үйлдвэрийн техник, технологи: /ажиллах горим, хүчин чадал/

Уурхайн олборлолтод ашиглах техник, тоног төхөөрөмж:

CATERPILLAR CAT-395 маркийн экскаватор 1ш	HOWO-371 маркийн автосамосвал 15ш
CATERPILLAR CAT-390 маркийн экскаватор 1ш	KOMATSU D-155 маркийн бульдозер 1ш
CATERPILLAR CAT-349 маркийн экскаватор 1ш	LIUGONG LG-956L маркийн утгуурт ачигч 3ш
DOOSAN DX-700LC маркийн экскаватор 1ш	

Баяжуулах, боловсруулах үйлдвэрт ашиглах тоног төхөөрөмж:

TK-50 маркийн хүрдэт шигшүүр 1ш	ХШ-700*8000*400 маркийн хоригт цорго 1ш
ХШ-700*6000*400 маркийн хоригт цорго 1ш	Труд-12м маркийн сепаратор 1ш
Д-1250 эзлэхүүнт насос 1ш	Мод 3м1 тунаах машин 1ш
Sagar маркийн хүрдэт шигшүүр 1ш	

Уурхайн алт гарган авах технологи нь олборлосон элсийг скруббер (хүрдэт шигшүүр)-ээр угаан ангилаад шлюз (хоригт цорго)-ээр /баяжуулалт → гүйцээн баяжуулалт/ баяжуулж, шлихийн аргаар алтыг гарган авна.

2023 онд уурхайд 200 хүн хоногт 2 ээлжээр, 20 цагаар, 180 хоног ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2023 онд 3,451.26 мян.м³ хөрс хуулж, 110.30 мян.м³ элс олборлон баяжуулж, 83.75 кг алт гарган авна. Биологийн нөхөн сэргээлт 1.87 га талбайд хийнэ. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 5000 ш мод тарина.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ: /шоо.метрээр/

Унд, ахуйд хэрэглэх усыг өөрийн эзэмшлийн талбайд гаргасан 4.0 л/сек ундаргатай ерөмдмөл худгаас, технологи, зам, талбайн тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаа, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усыг 8.6 км зайд байрлах Туул голоос болон уурхайн ухлагаас шавхан зайлуулах 121.0 м³/хон шүүрлийн уснаас хангана.

“Усны газар”-ын 2022.01.21-ны өдрийн 04/42 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах унд, ахуйн хэрэглээний 26.85 м³/хон усыг өөрийн эзэмшлийн талбайд гаргасан худгаас, технологи, зам талбайн усалгааны 2,532.6 м³/хон усны хэрэгцээг гүний худаг, уурхайд орох шүүрлийн 121.0 м³/хон ус, Туул голоос хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэсэн. Туул голын олон жилийн дундаж урсац 17.9м³/сек байх ба урсцын 0.096%-ийг зарцуулна гэсэн байна.

9. Усны барилга байгууламжууд: /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/

Тунаах сан 80,000.0 м³ багтаамжтай, хаягдлын сан 308,800.0 м³ багтаамжтай. Туул голоос ус татах шугам хоолой 8.6 км урттай, 250-400.0 мм голчтой, HDPE материалтай, эргэлтийн усан сангаас баяжуулах төхөөрөмжид ус татах шугам хоолой 250.0 м урттай, 150.0 мм голчтой HDPE материалтай, Тусгаарлах далангийн дунд 50.0 м урттай, 800.0 мм голчтой хос хоолойгоор ус халиагуур хийж эргэлтийн усан сан, тунаах сан хоёрыг хооронд нь холбоно.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур, /насосны хүчин чадал, марк/

Уртраг	Өргөрөг	Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын	
				Марк	Дугаар
104°29'12.04"	48°17'25.94"	4.0	QJ-7.5	-	-

Туул голоос MD-100-80x7 маркийн (100 м³/цаг) хүчин чадалтай насосоор эргэлтийн усан санд ус татдаг.

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

“Хаан булаг интернэйшнл” ХХК-ийн эзэмшлийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар наймганы дунд хэсэг, жалга-3,4 алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг 2022 онд “Говьхангайн төгөл” ХХК боловсруулж, батлуулсан.

12. Онцгой нөхцөл:

- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэхийг анхаарах;

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд:

$$110,300.0 \text{ м}^3 \times 4.0 \text{ м}^3/\text{тн} = 441,200.0 \text{ м}^3 \text{ ус шаардагдана}$$

Техникийн хүчин чадлаар тооцоход:

Баяжуулалтад 50.0 м³/цаг хүчин чадалтай скруббер 1 ш, 100.0 м³/цаг хүчин чадалтай скруббер 1 ш ашиглана.

150.0 м ³ /цаг х 20 цаг = 3,000.0м ³ /хон	- Хоногт угаах элсний хэмжээ
3,000.0 м ³ /хон х 4.0м ³ = 12,000.0 м ³ /хон	- Хоногт шаардагдах усны хэмжээ
12,000.0 м ³ /хон х 5 хон = 60,000.0 м ³	- Эргэлтийн усан санд тогтмол байх усны хэмжээ
110,300.0 м ³ : 3,000.0 м ³ /хон = 37 хон	- Элс угаан баяжуулахад зарцуулах хугацаа
12,000.0 м ³ /хон х 0.2 х 37 хон = 88,800.0 м ³	- Ууршил шүүрэлтээр алдагдах усны хэмжээ
32,000.0 м ² х 2.0л/м ² х 100 хон = 6,400.0 м ³	- зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус

$18,700.0 \text{ м}^2 \times 4.0 \text{ л/м}^2 \times 10 \text{ удаа} = 748.0 \text{ м}^3$	- биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ус
$5,000.0 \text{ ш/мод} \times 40 \text{ л/ш} \times 10 \text{ удаа} = 2,000.0 \text{ м}^3$	- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах ус
$60,000.0 \text{ м}^3 + 88,800.0 \text{ м}^3 + 6,400.0 \text{ м}^3 + 748.0 \text{ м}^3 + 2,000.0 \text{ м}^3 = 157,948.0 \text{ м}^3$	- Нийт шаардагдах усны хэмжээ
$121.0 \text{ м}^3/\text{хон} \times 180 \text{ хон} = 21,780.0 \text{ м}^3$	- Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ (БОННУ тайлан 71,72-ху) зам талбайн усалгаа, ногоон байгууламж, технологид эргүүлэн ашиглах
$157,948.0 \text{ м}^3 - 21,780.0 \text{ м}^3 = 136,168.0 \text{ м}^3$	- Технологид шаардагдах нийт усны хэмжээ
$200 \text{ хүн} \times 150.0 \text{ л/хон} \times 180 \text{ хон} = 5,400.0 \text{ м}^3$	- унд, ахуйн усны жилийн хэрэгцээ

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу хүн амын унд, ахуйн зориулалтаар ашиглах **5,400.0 м³** усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал баяжуулахад ашиглах **136,168.0 м³**, уурхайн ухлагаас шавхан зайлуулах **21,780.0 м³** усыг усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Туул голын сав газарт тогтоосон экологи-эдийн засгийн суурь үнэ, 2022 оны 416, 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор баталсан, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал баяжуулахад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:

$1 \text{ м}^3 \text{ гадаргын усны үнэ: } 2651 \text{ төг/м}^3 \times 0.25 \times 0.9 = 596.48 \text{ төг/м}^3$
 2651 төг/м^3 – Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
(25%) – 326-р тогтоолын 7(а)-д ашигт малтмал баяжуулахад гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
0.9– Ашигт малтмал баяжуулахад гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр;

$$136,168.0 \text{ м}^3 \times 596.48 \text{ төг/м}^3 = 81,221,488.6 \text{ төг}$$

Шавхан зайлуулах газрын доорх усны төлбөр:

$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9440 \text{ төг/м}^3 \times 0.15 \times 0.7 = 991.2 \text{ төг/м}^3$
 9440 төг/м^3 – Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
(15%) - 326-р тогтоолын 7(в)-д заасан газрын доорх усыг шавхан зайлуулахад тооцох төлбөрийн хувь, хэмжээ
